

**STUDIA ARCHAEOLOGICA  
INSTITUTI ARCHAEOLOGICI ACADEMIAE SCIENTIARUM  
MONGOLICAE**

Tomus (III) XXIII

Fasciculus 11

Л.МӨНХБАЯР

**ЭРДЭНЭЗУУ ХИЙДЭЭС ШИНЭЭР ОЛДСОН  
МОНГОЛ-НАНГИАД БИЧЭЭСИЙН УНШЛАГА**

Нангиад бичээс

Их Монгол улсын нийслэл Хархорум хотод хийж буй археологийн хээрийн шинжилгээний ажлын явцад нэгэн боржин хөшөөний хэсэг олдсон юм. Уг хөшөөний хагархай Монгол-Германы хамтарсан Кагакогум шинжилгээний ангийн KAR-1 хэсгийн салбар доктор Д.Баяр, магистрант О.Батсайхан нарын удирдсан хэсэг 2003 оны 8-р сарын 12-нд Эрдэнэ зуу хийдийн Цогчин дуганд хийсэн малтлагын явцад /малтлагын дугаараар 23-р баганы суурь болгож хийсэн/ илэрчээ.

Эл хөшөөний хэсэг нь гурвалжиндуу хэлбэртэй бөгөөд уртаараа 54 см, хамгийн өргөн хэсэгтээ 50 см, хамгийн нарийн хэсэгтээ 28 см, 34 см зузаантай бор шаргалдуу өнгийн боржин чулуун дээр бичээсийг сийлжээ. Бичээс нэг талдаа нангиад, нөгөө талдаа багахан монгол бичээстэй бөгөөд нангиад бичгийг нь тайлан унших оролдлого хийснээ толилуулж байна. Уг бичээсийн монгол бичигтэй хэсгийг археологич Р.Мөнхтулга уншив. Бичээс нийт 9 мөр, 97 ханз үсэгтэй бөгөөд баруунаас нь эхлүүлэн мөрлүүлсэн агаад бичээсийн үсгийн хувьд тод, гаргацтай, сайн хадгалагдсан бөгөөд уг бичээсийн 1 болон 2 мөр нь нэгэн адил утгатай буюу ханзнууд нь давтагдан орсон байна.

- 1-р мөрөнд 13 ханз үсэг
- 2-р мөрөнд 12 ханз үсэг
- 3-р мөрөнд 11 ханз үсэг
- 4-р мөрөнд 15 ханз үсэг
- 5-р мөрөнд 15 ханз үсэг
- 6-р мөрөнд 14 ханз үсэг
- 7-р мөрөнд 8 ханз үсэг
- 8-р мөрөнд 6 ханз үсэг
- 9-р мөрөнд 3 ханз үсэгтэй байна.

Уг бичээс нь нэгэн хөшөөний хагархай учраас утга төгссөн өгүүлбэр бараг алга бөгөөд хөшөөний бичээсийг дараах байдлаар уншиж болох мэт.

Нангиад бичээсийн ханзуудыг тэнхрүүлсэн байдал

IX	VIII	VII	VI	V	IV	III	II	I
不 銘 敕	精 至 重 三 其 門	武 備 卿 普 達 失 理 暨	延 慶 使 擗 思 監 輦 錙 葺 之 又 三 十 一	大 浮 屠 覆 以 傑 閣 鳩 功 方 殷 六 龍 狩 蜀	民 物 康 阜 始 建 宮 闕 因 築 梵 宇 而 末	十 五 年 歲 在 庚 辰 定 都 和 林	旨 榮 祿 大 夫 制 誥 無 修 國 史	旨 榮 祿 大 夫 制 誥 無 修 國 史 知

Мөрүүдийг бүтнээр утгачлан орчуулж сийрүүлбэл:

Нэгдүгээр мөр [1] [Төрд тэтгэсэн сайдын зарлигаар, улсын түүхчийн ухуулах зарлигийг зохиосон...] хэмээх утгатай байна.

旨-zhi-зарлиг

榮祿 - 大夫-dai fu- бол дайфу, түшмэл, эмч, оточ гэдэг утга агуулдаг бөгөөд уг мөрөнд байгаа дөрвөн ханз нийлж Төрд тэтгэсэн сайдын зарлиг хэмээх утга бүхий болж байна

誥-gao-ухуулах зарлиг

國-guo-улс, гүрэн

史-shi-түүх, шашдир гэх утгатай бөгөөд нийлбэл 國史 guo shi улсын түүхч хэмээх утгатай үг болно

Хоёрдугаар мөр [2] Нэгдүгээр мөртэй ижил

[Төрд тэтгэсэн сайдын зарлигаар, улсын түүхчийн ухуулаар зарлигийг зохиосон...] гэдэг утгатай болно.

旨-zhi-зарлиг

榮祿 - 大夫-dai fu- бол дайфу, түшмэл, эмч, оточ гэдэг утга агуулдаг бөгөөд уг мөрөнд байгаа дөрвөн ханз нийлж Төрд тэтгэсэн сайдын зарлиг хэмээх утга бүхий болж байна

誥-gao-ухуулах зарлиг

國-guo-улс, гүрэн

史-shi-түүх, шашдир гэх утгатай бөгөөд нийлбэл 國史 guo shi улсын түүх хэмээх утгатай үг болно

Гуравдугаар мөр [3] [...15-р оны цагаан луу жил Хархорумыг нийслэлээр тогтов буюу байгуулахаар болов] хэмээх утга бүхий болж байна.

庚-geng-цагаан хэмээх жилийн өнгө заах цагаан илэрхийлнэ.

辰-chen-луу жилийн нэр болно зөвхөн 12 жилийг заахад хэрэглэнэ

和-he -хятад хэлний сул үг бас хэмээх утгатай

林-lin-ой хэмээх утгатай хамтдаа 和林 he lin Хө линь буюу Хархорум хотыг тэмдэглэх хятад ханз

Дөрөвдүгээр мөр [4] [...ард олон энх амгалан, эд баялаг элбэг цагт эхлээд хааны орд харш байгуулаад улмаар, сүмийн гэр болон сүм барин, харин эцэст...]

宮-gong-орд, ордон

闕-que-осол, 宮闕-gong que-орд харш

梵-fan-сүм хийд

宇-yu-гэр, саравч, 梵宇-fan yu-сүмийн гэр буюу сүмийн барилга

Тавдугаар мөр [5] [...их суваргыг хучих аугаа /их/ асар /барих/ урчуудыг цуглуулж сая зургаан улаан луу Шу-д довтолж...]

浮-fu-дэгдэх, гүйх

屠-tu-алах, нядлах хэмээх утга бүхий ханз боловч хамтдаа 浮屠 fu tu хэмээх ханз бол бурхан, суврага хэмээх утга бүхий юм

閣-ke-тагт асар

Зургадугаар мөр [6] [...засуулахаар Ян чин ши Чогсүмээр тэрэг хэлхээ зоос хүргүүлээд дахин 31...]

延-yan-залах урих

慶-qing-бэлэглэх, тэмдэглэх

使-shi-элч, зарах илгээх элч хэмээх үг бөгөөд 延慶使 yan qing shi цол хэргэм

擿-shuo-чихэх хатгах

思-si-сахал санчиг

監-jian гяндан хэмээх утга бүхий ханз гэвч энэ 擿思監 shuo si jian 3 ханз нийлж Чогсүм хэмээх хүний нэрийг илэрхийлжээ

輦-nian-гэр тэрэг, их тэрэг

鋸-qiang-хэлхмэл зоос

葺-qi-засах сэлбэх

Долдугаар мөр [7] [...Ву-пей чинь /цэргийн хэрэг эрхэлсэн түшмэл /Будашир лугаа...]

武-wu-цэрэг, зэвсэг

備-bei-бэлтгэх, эрдэм чадал

卿-qing-эрхэлсэн түшмэл хэрэг хамаарагч 武備卿 wu bei qing-цэргийн хэрэг эрхэлсэн түшмэл

普-pu-нийт түгээмэл

達-da-нэвтэрхий

失-shi-салах алдах

理-li-судас хэмээх утга бүхий ханз боловч 普達失理-pu da shi li-Будашир хэмээх хүний нэр юм

暨-ji-лугаа, лүгээ гэсэн утгатай

Наймдугаар мөр [8] [...хүнд буюу том гурван хаалгат...]


Есдүгээр мөр [9] [...сийлмэл зарлиг үгүй...]

銘-ming-бичээс, сийлмэл бичиг

敕-ci – зарлиг хэмээн орчуулагдах бололтой.

Бид дээр эл шинээр олдсон гэрэлт хөшөөний хагархайн бичээсийг тэнхрүүлэн уншлаа. Бичээсийн эхийг үзээд бичлэг болон утгаас харахад энэ нь XIII-XIV-зууны үед холбогдох нангиад монгол бичигтэй нэгэн томоохон гэрэлт хөшөөний хагархай байж болохоор байна. Эл хөшөө Эрдэнэ-зуу хийдээс олдсон, эртний бичлэгтэй ханз зэргээс үзэхэд Их Монгол улсын нийслэл асан Хархорум хоттой ямар нэгэн хэмжээгээр холбогдох гэрэлт хөшөөний хагархай байж болох юм. Иймийн тул, Хархорум хавь, Эрдэнэ-зуу хийдээс урьд олдож асан өмнөх үеийн судалгаанд дурдагдсан гэрэлт хөшөөдийн хагархайтай холбоотой эсэхийг нягтлан үзэхийг оролдсу. Бидэнд мэдэгдэж байгаагаар, ..Сүмийн орчмоос нийт 16 бичээст чулуу олдсон бөгөөд 2 нь монгол бичигтэй үүний 1 нь маш эртний бололтой. Мөн төвд бичигтэй 1, перс бичигтэй 1 байлаа. Олдсон хятад бичигтэй хөшөөн дээр Хо лин 和林 мөн Та Хо лин 大和林, перс хөшөөн дээрхи бичээс уншихад хялбар байсан бөгөөд түүн дээр /Шехрь Ханбалык/ хэмээн В.В.Радловын удирдсан “Орхоны шинжилгээний ангийн” тайланд өгүүлсэн байх бөгөөд хэл бүрээр Хархорумын тухай бичжээ. Энэ бүх чулуунуудыг хийдийн ойролцоох хотоос авчирсан нь илт бөгөөд Чингис хааны анхны нийслэл болох Хархорум мөн гэдгийг батлаж байна<sup>1</sup> хэмээжээ.

<sup>1</sup> В.В.Радлов. Предварительный отчет о результатах для археологического исследования Бассейна реки Орхона. Сборник трудовъ Орхонской экспедицй № 1 СПб., 1892 с 10.



Бичээсийн хэв хуулга

## Summary

### Chinese inscription

In the capital city of Mongolian Empire Karakorum when the Mongolian-Germany joint project carried out archaeological research a new bilingual inscription found here.

This article is about the chinese text of sino-mongolian inscription which is founded from the Tsogchin dugan excavation of Erdene-Zuu monastery.

In this inscription have a 9 rows and 97 chinese letter.

1 row-13 chinese letter

2 row-12 chinese letter

3 row-11 chinese letter

4 row-15 chinese letter

5 row-15 chinese letter

6 row-14 chinese letter

7 row-8 chinese letter

8 row-6 chinese letter

9 row-3 chinese letter

In this inscription was written the ...in the fifteen year of Tai-tsu, when the cyclical year keng chen /1220/, he established the capital at Ho lin. /Karakorum /Qara qorum/ the capital city of the Mongol Empire/, built a khan palace, a Great stupa and one Pavilion had been reconstructed and which is established in 1256 during the Mongka khan time.